

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2024/14/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2024 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Назгүл
Утас: 99427301 Цахим хаяг: Nazgul.D@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.5.2 Авлага.....	17
3.5.3 Урьдчилгаа	17
3.5.4 Бараа материал.....	17
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:.....	18
3.5.6 Үндсэн хөрөнгө.....	18
3.5.7 Өр төлбөр.....	19
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	19
4. АУДИТЫН ТАЙЛАН	23
4.1 Ерөнхий зүйл	23
4.2 Материаллаг байдал.....	24
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	24
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	24
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	25
4.5.1 Завсрын аудитын талаар.....	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	25
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	25
1. Төлбөрийн акт.....	26
5.2 Албан шаардлага.....	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	26

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт
УАГ	Үндэсний аудитын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Х.НУРБОЛАТ ТАНАА

2024.03.25 № 363
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402345

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,333.82</u>	<u>1,554.30</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	283.85	303.22
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	283.85	303.22
3121	Төгрөг	283.85	303.22
31211	Төрийн сангийн харилцах	190.90	303.22
31213	Арилжааны банк дахь харилцах	92.95	-
33	АВЛАГА	834.13	905.45
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3.62	1.84
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	15.93	113.50
335	Бусад авлага	1.93	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1.93	-
336	Зээлийн авлага	812.65	790.12
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	812.65	790.12
33612	Хувь хүмүүст олгосон зээл	812.65	790.12
35	БАРАА МАТЕРИАЛ	215.84	345.63
351	Түүхий эд материал	104.43	119.70
35130	Эм боох материал	104.43	119.70
354	Хангамжийн материал	111.41	225.93
35410	Бичиг хэргийн материал	0.43	0.73
35420	Аж ахуйн материал	102.66	182.64
35430	Сэлбэг хэрэгсэл	-	11.29
35440	Түлш, шатах тослох материал	2.34	22.25
35470	Бусад хангамжийн материал	5.98	9.02
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>24,347.92</u>	<u>25,913.97</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	24,347.92	25,913.97
392	Биет хөрөнгө	19,948.63	21,512.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,961.07	2,036.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	(276.33)	(338.07)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,386.77	1,307.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(359.04)	(284.90)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	545.32	694.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	(220.35)	(304.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	179.01	197.54
39208	Хуримтлагдсан элэгдэл	(87.96)	(102.56)
39209	Зам, гүүрийн байгууламж	13,365.43	15,095.74
39210	Хуримтлагдсан элэгдэл	(1,028.11)	(1,799.19)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,279.27	6,978.42
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,797.32)	(1,986.81)
39217	Ном	0.87	16.87

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

393	Биет бус хөрөнгө	4,399.29	4,401.93
39301	Програм хангамж	2.26	5.10
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1.90)	(2.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,398.94	4,398.94
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>25,681.75</u>	<u>27,468.26</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>349.28</u>	<u>395.15</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	349.28	395.15
413	Өглөг	349.28	395.15
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	7.56	23.99
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	305.86	305.86
4136	Бусад өглөг	35.86	65.29
41361	Байгууллагад төлөх өглөг	35.86	65.29
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>25,332.46</u>	<u>27,073.12</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	25,332.46	27,073.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,519.08	5,519.08
51101	Өмч: - төрийн	5,519.08	5,519.08
512	Хуримтлагдсан үр дүн	19,319.87	21,060.53
51210	Өмнөх үеийн үр дүн	55,504.50	19,389.88
51220	Тайлант үеийн үр дүн	(36,184.63)	1,670.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	493.51	493.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>25,681.75</u>	<u>27,468.26</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,970.08	20,562.77
11	ТАТВАРЫН ОРЛОГО	6,448.86	9,009.67
110	Орлогын албан татвар	6,098.07	8,505.94
1100	Хувь хүний орлогын албан татвар	6,705.27	9,249.15
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	5,599.54	7,844.19
110002	Үйл ажиллагааны орлого	279.60	322.79
110003	Хөрөнгийн орлого	662.86	705.79
110004	Хөрөнгө борлуулсны орлого	163.27	376.39
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(607.21)	(743.21)
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(607.21)	(743.21)
113	Хөрөнгийн албан татвар	155.64	239.59
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	144.98	232.29
113002	Бууны албан татвар	10.51	6.10
113004	Малд ногдуулах албан татвар	0.15	1.20

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

118	Бусад татвар, төлбөр, хураамж	195.15	264.13
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	58.07	65.25
118001	Улсын тэмдэгтийн хураамж	49.21	49.17
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	5.50	1.54
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3.36	14.54
1181	Газрын төлбөр	136.83	198.83
118101	Газрын төлбөр	136.83	198.83
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.26	0.05
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.26	0.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,774.27	3,131.87
120	Нийтлэг татварын бус орлого	2,774.27	3,131.87
120003	Торгуулийн орлого	288.04	250.87
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	16.62	26.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16.62	22.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4.64
120009	Бусад орлого	310.39	334.49
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	2,094.78	2,504.37
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	64.45	15.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,746.94	8,421.24
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	230.41	489.21
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8.62	8.73
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	204.95	450.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16.84	30.48
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	412.34	5,349.78
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	4,615.50
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	412.34	734.29
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,104.19	2,582.25
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,104.19	2,582.25
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,402.11	18,180.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,402.11	18,180.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,008.21	8,926.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,756.56	1,037.28
210101	Үндсэн цалин	1,505.43	689.63
210102	Нэмэгдэл	124.94	288.19
210104	Урамшуулал	70.26	59.46
210105	Гэрээт ажлын хөлс	55.92	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	215.50	134.30
210201	Тэтгэврийн даатгал	145.31	96.30
210202	Тэтгэмжийн даатгал	23.87	9.50

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210203	ҮОМШӨ-ний даатгал	12.35	7.60
210204	Ажилгүйдлийн даатгал	3.09	1.90
210205	Эрүүл мэндийн даатгал	30.88	19.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,692.48	48.99
210301	Гэрэл, цахилгаан	116.17	7.65
210302	Түлш, халаалт	1,446.47	38.44
210303	Цэвэр, бохир ус	129.83	2.90
2104	Хангамж, бараа материалын зардал	50.90	54.22
210401	Бичиг хэрэг	6.76	8.37
210402	Тээвэр, шатахуун	37.93	39.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6.04	6.44
210404	Ном, хэвлэл	-	0.03
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.17	0.39
2105	Нормативт зардал	1.19	1.14
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1.19	1.14
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43.28	3.05
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.11	0.87
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1.33	1.08
210604	Урсгал засвар	41.83	1.10
2107	Томилолт, зочны зардал	4.76	14.58
210702	Дотоод албан томилолт	4.76	14.58
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	163.88	474.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	162.23	472.68
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.46	-
210803	Даатгалын үйлчилгээ	0.14	0.33
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.18	0.40
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.14	0.35
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.61	0.92
210807	Газрын төлбөр	0.07	0.13
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.01	0.02
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.02	0.02
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,079.66	7,157.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,400.91	5,959.13
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.79	1.69
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,677.96	1,197.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,393.89	9,254.26
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,008.12	4,615.50
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	3,008.12	4,615.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	81.41	23.26
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30.06	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51.35	18.47
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4.79

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	304.36	4,615.50
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	304.36	4,615.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	567.97	2,382.23
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	36,752.60	711.58
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	0.53
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө	35,811.45	711.05
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал	941.15	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(36,752.60)	(711.58)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(36,184.63)	1,670.64

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	9,942.89	18,203.44
11	ТАТВАРЫН ОРЛОГО	6,448.86	9,009.67
110	Орлогын албан татвар	6,098.07	8,505.94
1100	Хувь хүний орлогын албан татвар	6,705.27	9,249.15
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	5,599.54	7,844.19
110002	Үйл ажиллагааны орлого	279.60	322.79
110003	Хөрөнгийн орлого	662.86	705.79
110004	Хөрөнгө борлуулсны орлого	163.27	376.39
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(607.21)	(743.21)
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(607.21)	(743.21)
113	Хөрөнгийн албан татвар	155.64	239.59
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	144.98	232.29
113002	Бууны албан татвар	10.51	6.10
113004	Малд ногдуулах албан татвар	0.15	1.20
118	Бусад татвар, төлбөр, хураамж	195.15	264.13
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	58.07	65.25
118001	Улсын тэмдэгтийн хураамж	49.21	49.17
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	5.50	1.54
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3.36	14.54
1181	Газрын төлбөр	136.83	198.83
118101	Газрын төлбөр	136.83	198.83
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.26	0.05
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.26	0.05

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	747.09	772.53
120	Нийтлэг татварын бус орлого	747.09	772.53
120003	Торгуулийн орлого	288.04	250.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	148.67	187.17
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	148.67	182.53
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4.64
120009	Бусад орлого	310.39	334.49
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,746.94	8,421.24
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	230.41	489.21
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8.62	8.73
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	204.95	450.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16.84	30.48
131106	Төсвийн урамшуулал	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	412.34	5,349.78
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	4,615.50
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	412.34	734.29
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,104.19	2,582.25
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,104.19	2,582.25
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	10,075.57	17,283.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,075.57	17,283.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,620.60	8,029.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,765.20	1,039.35
210101	Үндсэн цалин	1,507.11	664.51
210102	Нэмэгдэл	124.94	344.80
210104	Урамшуулал	71.93	30.04
210105	Гэрээт ажлын хөлс	61.21	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	215.50	135.35
210201	Тэтгэврийн даатгал	145.31	93.59
210202	Тэтгэмжийн даатгал	23.87	10.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	12.35	8.35
210204	Ажилгүйдлийн даатгал	3.09	2.09
210205	Эрүүл мэндийн даатгал	30.88	20.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,692.58	48.99
210301	Гэрэл, цахилгаан	115.27	7.20
210302	Түлш, халаалт	1,446.92	38.54
210303	Цэвэр, бохир ус	130.39	3.25
2104	Хангамж, бараа материалын зардал	47.52	52.99
210401	Бичиг хэрэг	6.52	7.57
210402	Тээвэр, шатахуун	34.92	38.56
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6.00	6.46
210404	Ном, хэвлэл	0.09	0.39

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	1.19	1.14
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1.19	1.14
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43.30	3.05
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.11	0.87
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1.48	1.08
210604	Урсгал засвар	41.71	1.10
2107	Томилолт, зочны зардал	4.76	14.58
210702	Дотоод албан томилолт	4.76	14.58
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	159.37	462.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	157.73	459.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.52	0.10
210803	Даатгалын үйлчилгээ	0.09	0.23
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.18	0.40
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.14	0.35
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.61	0.95
210807	Газрын төлбөр	0.07	0.13
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.01	0.02
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.02	0.02
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,691.17	6,272.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,690.38	6,270.37
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.79	1.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,454.97	9,254.26
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,373.56	4,615.50
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	3,373.56	4,615.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	81.41	23.26
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30.06	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51.35	18.47
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4.79
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	4,615.50
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	-	4,615.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(132.68)	919.66
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	120.68	900.29
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	120.68	900.29
2200	Дотоод эх үүсвэрээр	120.68	900.29
220001	Барилга байгууламж	-	497.86
221001	Их засвар	-	93.07
222001	Тоног төхөөрөмж	-	98.43
223001	Бусад хөрөнгө	-	21.69

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	120.68	189.24
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(120.68)	(900.29)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(253.36)	19.37
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	537.21	283.85
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	283.85	303.22

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	14,965.53	12,206.90	34,164.23	61,336.65
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-9,452.45	-11,713.38	21,340.28	174.44
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,513.08	493.51	55,504.50	61,511.09
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	6.00	0.00	0.00	6.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-36,184.63	-36,184.63
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,519.08	493.51	19,319.87	25,332.46
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,519.08	493.51	19,319.87	25,332.46
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	70.01	70.01
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,519.08	493.51	19,389.88	25,402.47
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,670.64	1,670.64
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,519.08	493.51	21,060.53	27,073.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,469.08	10,405.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,730.99	9,684.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,092.16	5,045.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,046.18	1,039.35
210101	Үндсэн цалин	666.51	664.51
210102	Нэмэгдэл	349.63	344.80
210104	Урамшуулал	30.04	30.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135.35	135.35
210201	Тэтгэврийн даатгал	93.59	93.59
210202	Тэтгэмжийн даатгал	10.44	10.44

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210203	ҮОМШӨ-ний даатгал	8.35	8.35
210204	Ажилгүйдлийн даатгал	2.09	2.09
210205	Эрүүл мэндийн даатгал	20.88	20.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,014.69	3,000.11
210301	Гэрэл, цахилгаан	180.96	174.74
210302	Түлш, халаалт	2,325.14	2,318.25
210303	Цэвэр, бохир ус	146.23	144.76
210304	Байрны түрээс	362.36	362.36
2104	Хангамж, бараа материалын зардал	52.17	52.17
210401	Бичиг хэрэг	8.37	8.37
210402	Тээвэр, шатахуун	36.94	36.94
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6.46	6.46
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.39	0.39
2105	Нормативт зардал	1.19	1.14
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1.19	1.14
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34.98	34.60
210601	Багаж, техник, хэрэгсэл	1.11	0.87
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1.08	1.08
210604	Урсгал засвар	32.80	32.66
2107	Томилолт, зочны зардал	12.97	14.58
210702	Дотоод албан томилолт	12.97	14.58
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	471.92	466.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	469.36	464.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.39	0.10
210803	Даатгалын үйлчилгээ	0.29	0.23
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.40	0.40
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.35	0.35
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.95	0.95
210807	Газрын төлбөр	0.13	0.13
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.02	0.02
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.02	0.02
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	322.69	302.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	321.00	300.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1.69	1.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,638.83	4,638.76
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,615.50	4,615.50
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	4,615.50	4,615.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	23.33	23.26
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18.47	18.47
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4.86	4.79
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	738.09	721.05
2200	Дотоод эх үүсвэрээр	738.09	721.05
220001	Барилга байгууламж	509.54	507.86
221001	Их засвар	100.00	93.07
222001	Тоног төхөөрөмж	100.00	98.43
223001	Бусад хөрөнгө	28.54	21.69
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,469.08	10,437.57
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,284.08	10,249.45
132001	Орон нутгийн төсвөөс	9,549.79	9,515.16

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	734.29	734.29
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	185.00	188.13
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	185.00	183.49
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4.64
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		188.93
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		220.70
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	15	15
610001	Төсвийн байгууллага	15	15
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	52	52
620001	Удирдах ажилтан	18	18
620002	Гүйцэтгэх ажилтан	22	22
620003	Үйлчлэх ажилтан	8	8
620004	Гэрээт ажилтан	4	4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	52	52
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	13	13
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19	19
650010	Гэрээт ажилтан	4	4
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	16	16

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	499.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	496.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	496.13
2104	Хангамж, бараа материалын зардал	1.62
210402	Тээвэр, шатахуун	1.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	494.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	494.51
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.68
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	0.68
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2.47
2200	Дотоод эх үүсвэрээр	2.47
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2.47
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	499.28
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	499.28
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	460.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30.48
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Өлгий сумын Засаг даргын ажлын алба нь Засгийн газрын бодлого, шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах, сумын хүн, ам, ХХАА-н үйлдвэрлэл, үйлчилгээний бүртгэл судалгааг хөтөлж, дээд шатны байгууллагыг мэдээ, мэдээллээр хангах, сумын хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, тайлагнах болон харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөгөө зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ИТХ, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллага юм.

Өлгий сумын Засаг даргын ажлын албаны эрхэм зорилго нь “Баян-Өлгий аймгийн газар орны онцлог, үндэстэн, ястны өвөрмөц байдал, үнэт зүйл, биет болон биет бус өвийг хадгалан хамгаалж, эв нэгдлийг хангах”-д оршино.

Дээрх зорилгын хүрээнд “Орон нутгийн үндэстэн ястны онцлогт тулгуурласан хамтын үнэт зүйл, хөгжил тэмүүлэл, соёлын олон илэрхийллийг тэгш харуулсан, оновчтой зохион байгуулалт, менежмент бүхий төрийн захиргааны мэргэжлийн байгууллага байх” зорилт дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Өлгий сумын Засаг дарга нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоомжуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага ба Өлгий сумын Засаг даргын харьяа байгууллагуудаас Хот тохижуулах албаны 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалт хийсэн, ЗДТГ, ИТХ-д хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккрузал суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын 2020 онд баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,786.5 сая төгрөгөөр буюу 6.9 хувиар өссөн байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	283.85	303.22	19.37
Авлага	834.13	905.45	71.33
Бараа материал	215.84	345.63	129.78
Үндсэн хөрөнгө	24,347.92	25,913.97	1,566.04
Нийт хөрөнгө	25,681.75	27,468.26	1,786.52
Өр төлбөр	349.28	395.15	45.86
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	25,332.46	27,073.12	1,740.65
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	25,681.75	27,468.26	1,786.52

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансдад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 303.2 сая төгрөг болж, оны эхнээс 19.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	283.85	303.22	19.37
Төгрөг	283.85	303.22	19.37
Төрийн сангийн харилцах	190.90	303.22	112.32
Арилжааны банк дахь харилцах	92.95	-	(92.95)
Дүн	283.85	303.22	19.37

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Орон нутгийн ерөнхий орлогын данс 82.5 сая, ОНХС-гийн данс 38.4 сая, Хоршоо хөгжүүлэх сан 182.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Мөнгөн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 905.4 сая төгрөг болж, өмнөх оноос 71.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	3.62	1.84	(1.78)
Төлбөртэй үйлчилгээний авлага	15.93	113.50	97.57
Бусад авлага	1.93	-	(1.93)
Хувь хүмүүсээс авах авлага	1.93	-	(1.93)
Зээлийн авлага	812.65	790.12	(22.53)
Хувь хүмүүст олгосон зээл	812.65	790.12	(22.53)
Дүн	834.13	905.45	71.33

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 71.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Өрхийн эмнэлгүүдийн авлага оны эхнээс 98.2 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Нийт авлагын 87.2 хувь нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага байна.

Аудитын илрүүлэлт:

Авлага данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардал дансанд өөрчлөлт ороогүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 345.6 сая төгрөг болж, оны эхнээс 129.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

БӨА-2024/01/НА-СТА-ТТЗ

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	104.43	119.70	15.27
Эм боох материал	104.43	119.70	15.27
Хангамжийн материал	111.41	225.93	114.51
Бичиг хэргийн материал	0.43	0.73	0.30
Аж ахуйн материал	102.66	182.64	79.98
Сэлбэг хэрэгсэл	-	11.29	11.29
Түлш, шатах тослох материал	2.34	22.25	19.91
Бусад хангамжийн материал	5.98	9.02	3.04
Дүн	215.84	345.63	129.78

Бараа материалын данс оны эхнээс 80.5 сая төгрөгөөр өссөн нь Хот тохижуулах алба тайлант онд төсвийн хөрөнгөөр 283.7 сая төгрөгийн бараа материал худалдан авч 199.3 сая төгрөгийг зарцуулж 94.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалыг 17,365.0 мянган төгрөгөөр алдаатай тусгасныг залруулсан байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө:

Бусад эргэлтийн хөрөнгийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 30,731.9 сая төгрөг болж, өмнөх оноос 2,612.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	23,717.73	26,327.84	2,610.10
Барилга, байгууламж, орон сууц	1,961.07	2,036.70	75.63
Авто-тээврийн хэрэгсэл	1,386.77	1,307.78	(78.99)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	545.32	694.79	149.47
Тавилга, аж ахуйн эд хогшил	179.01	197.54	18.53
Зам, гүүр-ийн байгууламж	13,365.43	15,095.74	1,730.31
Бусад үндсэн хөрөнгө	6,279.27	6,978.42	699.14
Ном	0.87	16.87	16.00
Биет бус хөрөнгө	4,401.20	4,404.04	2.85
Программ хангамж	2.26	5.10	2.85
Бусад биет бус хөрөнгө	4,398.94	4,398.94	-
Дүн	28,118.93	30,731.88	2,612.95

Үндсэн хөрөнгийн данс цэвэр дүнгээр оны эхнээс 2,744.4 сая төгрөгөөр өссөн нь ЗДТГ 1,753.4 сая, Хот тохижуулах 750.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Үндсэн хөрөнгө данстай холбоотой зөрчил гараагүй.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн данс оны эцэст 395.2 сая төгрөг болж, 45.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Өглөг	313.43	329.86	16.43
Ажилчидтай холбогдсон өглөг	7.56	23.99	16.43
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	305.86	305.86	-
Бусад өглөг	35.86	65.29	29.43
Байгууллагад төлөх өглөг	35.86	65.29	29.43
Дүн	349.28	395.15	45.86

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Татаас, санхүүжилт, шилжүүлгийн он дамжсан өглөг 305.8 сая төгрөгийн өглөг байна. Сумын ИТХ ажилчидтай холбоотой 5.5 сая төгрөгийн өглөгийг барагдуулж Өрхийн эмнэлэг оны эхэнд байсан 2.0 сая төгрөгийн өглөг дээр шинээр 22.0 сая төгрөгийн ажиллагсадтай холбоотой өглөг үүсгэсэн байна. Хот тохижуулах алба оны эхэнд байсан 35.8 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөгийг барагдуулсан бол Өрхийн эмнэлгүүд оны эцэст байгууллагад төлөх 65.3 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

Өглөг данстай холбоотой алдаа, зөрчил гараагүй.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 27,073.1 сая төгрөг болж, тайлант оны үр дүн 1,670.6 сая төгрөг болон хуримтлагдсан үр дүн дансанд хийсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн 70.6 сая төгрөг, нийт 1,740.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	/ сая төгрөгөөр		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	5,519.08	5,519.08	0
Хуримтлагдсан үр дүн	19,813.38	21,554.04	1,740.65
Өмнөх үеийн үр дүн	55,504.50	19,389.88	(36,114.62)
Тайлант үеийн үр дүн	(36,184.63)	1,670.64	37,855.27
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	493.51	493.51	-
Дүн	25,332.46	27,073.12	1,740.65

Эх сурвалж: Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Өлгий сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрт зориулан нийтдээ 10,469.1 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 9,730.9 сая төгрөгийг урсгал зардалд, 738.1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 4,615.5 сая төгрөгийг улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр, 4,934.3 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвийн орлогоос, 734.3 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхээр, 185.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэн санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд гүйцэтгэлээр нийтдээ 10,437.6 сая төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлснээс улсын төсвөөс 4,615.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, сумын орон нутгийн төсвөөс 4,934.3 сая төгрөгийн, Орон нутгийн хөгжлийн сангаас 734.3 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 183.5 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 4.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж зарцуулсан байна.

Орон нутгийн төсвөөс авахаар төлөвлөсөн санхүүжилтээс 9.5 сая төгрөгийг дутуу авч, оны эцэст орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 25.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сангаас орох үндсэн үйл ажиллагааны орлогыг 170.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 167.9 сая төгрөг оруулж, 2.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Хот тохижуулах албаны үндсэн үйл ажиллагаанаас оруулах орлогын төлөвлөгөө 15.0 сая төгрөг ба гүйцэтгэлээр 15.6 сая төгрөг оруулж 0.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Туслах үйл ажиллагааны орлогод орсон 4.6 сая төгрөг нь Өлгий сумын 18 дугаар цэцэрлэгтэй холбоотой 2023/ШЦТ/31 тоот шүүхийн шийдвэрээр орсон орлого байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 10,405.8 сая төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь дутуу авсан санхүүжилт болон төвлөрүүлэх шилжүүлэг, тасарсан орлого, тайлант оны орлогоос 31.8 сая төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

Сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар зөрчил гараагүй.

Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар:

-Засаг даргын Тамгын газрын Санхүү, албаны даргын албан тушаалтан эрхэлдэг албан хаагчид сумын Засаг даргын 2021 оны Б/12 дугаар захирамжаар Улаан загалмайн нийгэмлэгийн ажлыг хавсран гүйцэтгэсний 40 хувь нэмэгдэл олгох шийдвэрийн дагуу 2023 оны 1-2 дугаар сард нийт 739.6 мянган төгрөг олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоогдсон.

- Төрийн захиргааны албан тушаал эрхэлдэг албан хаагчдад 30 хувиар тооцож, нийт 68,462.7 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдлийг тушаал, шийдвэргүй олгосон, Сумын Засаг даргад 4,077.5 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг бүрдэл дутуу баримтаар олгосон, цалингийн зардлаас 6,720.0 мянган төгрөгийг нүүрсний хөнгөлөлтөд, албан томилолтын зардлаас 2,350.5 мянган төгрөгийг хувь хүний орлогын албан татварт нийт 9,070.5 мянган төгрөгийг зөвшөөрөлгүй шилжүүлсэн зөрчилд зөвлөмж өгөгдсөн.

Сумын ИТХ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар:

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

-Мөнгийн гүйлгээний тайланд өмнөх оны үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн 44,075.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулсан.

-Тээвэр шатахууны зардалд 6,525.0 мянган төгрөгийн зарцуулсан боловч замын хуудас хөтлөөгүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчилд зөвлөмж өгөгдсөн.

Сумын орон нутгийн төсвийн орлогын талаар:

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 183.5 сая төгрөгийн орлого бүрдүүлснээс 167.9 сая төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс, 15.6 сая төгрөг нь Хот тохижуулах албаны үндсэн үйл ажиллагаанаас орсон орлого байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны “Орон нутгийн төсөв батлах тухай” 132 дугаар тогтоолоор Өлгий сумын 2023 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 8,271.3 сая төгрөгөөр баталж, Аймгийн ИТХ-ын хуралдааны “2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 2023 оны 192 дугаар тодотголоор 903.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 9,174.5 сая төгрөгөөр тодотгож баталсан байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 35 дугаар тогтоолоор 2023 орлогын төлөвлөгөөг 8,711.5 сая төгрөгөөр баталсан бол сумын ИТХ-ын 2023 оны “Өлгий сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 53 дугаар тогтоолоор 2023 орлогын төлөвлөгөөг анх баталснаас 21.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 9,573.7 сая төгрөгөөр тодотгож баталсан байна. /ХХОАТ-ын буцаалтыг хассан дүнгээр/

Гүйцэтгэлээр тайлант онд 9,610.6 сая төгрөгийн орлого оруулж /ХХОАТ-ын буцаалтыг хассан дүнгээр/ орлогын төлөвлөгөөг 33.1 сая төгрөгөөр буюу 3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварын орлогоос ХХОАТ-ын буцаан олголтод 743.2 сая төгрөг олгосон байна.

Хүснэгт №2 Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Төлөвлөгөө</u>	<u>Гүйцэтгэл</u>	<u>Өсөлт/+, бууралт -/</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
I.Татварын орлого	8,562.5	9,009.7	447.2	105.2%
II.Татварын бус орлого	1,015.0	600.9	-414.1	59.2%
Нийт дүн	9,577.5	9,610.6	33.1	100.3%

Орон нутгийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд хувь хүний орлогын албан татвар 770.9 сая төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд:

Татварын орлогоос - Хувь хүний орлогын албан татвар нийт дүнгээрээ 770.9 сая төгрөгөөр давж биелсэн ба цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар 674.7 сая, үйл ажиллагааны орлого 108.9 сая, хөрөнгө борлуулсны орлогын татвар 131.9 сая төгрөгөөр тус тус давж, хувь хүний орлогын албан татварын буцаалтыг 2.7 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан бол хөрөнгийн орлого 147.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Өмчийн татвар нийт дүнгээрээ 180.4 сая төгрөгөөр тасарсны дотор үл хөдлөх хөрөнгийн албан татвар 177.4 сая, бууны албан татвар 0.4 сая малд ногдуулах албан татвар 2.6 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусад татвар, төлбөр, хураамжийн орлого нийт дүнгээрээ 143.3 сая төгрөгөөр тасарсны дотор улсын тэмдэгтийн хураамж 8.2 сая төгрөгөөр давж, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 148.5 сая, хог хаягдлын хураамж 105.4 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс ус, рашаан ашигласны төлбөр хураамжийн орлого 0.05 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Татварын бус орлого нийт дүнгээрээ 414.1 сая төгрөгөөр тасарсан бол хүү, торгуулийн орлого 549.1 сая төгрөгөөр тасарч нэр заагдаагүй бусад орлого 134.5 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 0.6 сая төгрөгөөр давж биелсэн байна.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 1.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар хувь хүний орлогын албан татварын буцаалтыг нэмж тооцоход 10,353.8 сая төгрөгийн татварын орлого оруулж, орон нутгийн төсвийн төвлөрүүлэлтийн орлогоос 25.8 сая, нийт 10,379.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 10,299.1 сая төгрөгийн төсвийг зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 82.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт №3 Төсвийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлтийн талаар:

/сая төгрөг/

№	Байгууллагын нэр	2023 оны		Зөрүү	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	дүнгээр	хувиар
1	Сумын ИТХ	267.39	262.56	4.83	98%
2	Сумын ЗДТГ	1,241.26	1,235.19	6.07	99.5%
3	Хот тохижуулах алба	439.44	439.44	-	100%
4	Сум хөгжүүлэх сан	170.00	149.38	20.62	88%
5	Сумын орон нутгийн хөгжлийн сан	738.09	721.05	17.03	98%
	Орон нутгийн дүн	2,856.18	2,807.63	48.55	
1	Аймагт төвлөрүүлэх тэгшитгэл	4,615.50	4,615.50	-	100%
2	Ерөнхий боловсролын сургуулиуд	2,004.24	2,001.20	3.04	100%
3	Хүүхдийн цэцэрлэгүүд	985.64	976.48	9.16	99%
4	Эрүүл мэндийн төв	7.52	4.99	2.52	66%
5	Бусад дүн	7,612.90	7,598.18	14.72	100%
	Нийт дүн	10,469.08	10,405.80	63.27	99%

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд нийт 10,469.1 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 10,405.8 сая төгрөгийн төсвийг зарцуулж 99.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнд: Сумын ИТХ 4.8 сая, ЗДТГ 6.0 сая, Хоршоог хөгжүүлэх сан 20.6 сая, Орон нутгийн хөгжлийн сан 17.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Сумын ЗДТГ 1,241.3 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 1,241.3 сая төгрөгийн санхүүжилт авч 6.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 99.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Сумын ИТХ 267.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 262.5 сая төгрөгийн санхүүжилт авч 4.8 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан ба төсвийн гүйцэтгэл 98 хувьтай байна.

Сумын Орон нутгийн хөгжлийн сан төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан нь зарцуулалттай холбоотой боловч орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх 3.8 сая төгрөгийн санхүүжилтийг БӨА-2024/01/НА-СТА-ТТЗ

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

аваагүй байна. Хоршоог хөгжүүлэх сан зээлийн эргэн төлөлтөөс орсон орлогын гүйцэтгэлтэй холбоотой төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй гарсан байна.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, Эрүүл мэндийн төвүүдийн тогтмол зардал 14.7 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарсан нь хэмнэлтийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Өлгий сумын ИТХ 10.0 сая, ЗДТГ 5.7 сая, Хот тохижуулах алба 473.6 сая, нийт 499.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна. Үүнд: Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс ЗДТГ 7.7 сая, Хот тохижуулах алба 1.1 сая нийт 8.8 сая, Дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагчийн төсөвт хуваарилсан хөрөнгөөс Хот тохижуулах алба 450.0 сая, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос ИТХ 10.0 сая, ЗДТГ 8.0 сая, Хот тохижуулах алба 22.5 сая, нийт 40.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна.

Үүнээс: Тээвэр шатахууны зардалд 1.6 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 494.5 сая, биет ба биет бус хөрөнгө худалдан авахад 2.5 сая төгрөгийг зарцуулж 0.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэл, орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн тайланг 2024 оны 3 дүгээр сарын 04-ний өдрийн 1/115 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгө 24,468.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 244.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатанд Өлгий сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгө 27,468.3 сая төгрөгөөс 1 хувиар тооцоход материаллаг байдлын түвшин 274.7 сая төгрөг байна

Энэ нь төлөвлөлтийн үе шатанд төлөвлөсөн материаллаг байдлын түвшнээс 30.0 сая төгрөгөөр их байгаа тул материаллаг байдлын түвшнийг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн үе шатанд 274.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор сумын төсөв байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд үйл ажиллагаатай хамааралтай 3 шалгуурт алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад мэдээллүүдийг бүрэн оруулсан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт:

Сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар шилэн данстай холбоотой зөрчил гараагүй.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой илэрсэн зөрчлийг арилгах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага өгөгдсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчид завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил гараагүй боловч аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар бүх сумын Засаг дарга нарт малын татварын төлөвлөлт, бүрдүүлэлтийн талаар “Малын татвараас орох орлогыг үндэслэлтэй төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулж, орлогыг сумын төсвийн орлогод бүрэн төвлөрүүлж ажиллах” зөвлөмж өгсөн.

Зөвлөмжийг хэрэгжилтийг шалгахад Өлгий сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн “Өлгий сумын 2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 53 дугаар тогтоолоор малын татварын орлогыг 3.8 сая төгрөгөөр төлөвлөж, 1.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 3 төсвийн байгууллага, 2 тусгай сан болон сумын төрийн сангуудын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 2 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 2 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд, Эрүүл мэндийн төвд орон нутгийн төсвөөс олгосон тогтмол зардлын санхүүжилтийг нэгтгэлд хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн. Сумын ИТХ, Хот тохижуулах алба, Орон нутгийн хөгжлийн сан, Хоршоог хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж үзсэн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,096.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 61.5 сая төгрөгийн залруулга хийгдэж, 0.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоогдож, 1,403.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 630.9 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгөгдсөн байна.

Хүснэгт №5: Төсөвт байгууллагуудын алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/Д		Үүнээс
-----	--	--------

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өлгий сумын ЗДТГ	5	1,322.7	1	17.4	1	0.7	2	1,223.0	3	81.6
2	Өлгий сумын ИТХ	2	50.6	1	44.1					1	6.5
3	Хот тохижуулах алба	2	542.8							2	542.8
3	Өлгий сумын ОНХС										
4	Өлгий сумын ХХС	1	180.5					1	180.5		
	Дүн	10	2,096.6	2	61.5	1	0.7	3	1,403.5	6	630.9

Эх сурвалж: Аудитын зөрчлийн мэдээ

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар зөрчил¹ илрээгүй.

1. Төлбөрийн акт

Акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								